



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 1/23

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа
болон аюулгүй байдлыг хангуулах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Иргэний нисэхийн ерөнхий газрын нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын хариуцлагыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор авч хэрэгжүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгасугай. Үүнд:

1. Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр:
 - 1.1. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын албаны үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх, дарга, менежер, байцаагчид тавигдах ажлын байрны шаардлагыг нягтлан үзэж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулж баталгаажуулах;
 - 1.2. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагчийг чиг үүргийнх нь дагуу мэргэжил, туршлагыг харгалzan сонгон шалгаруулах, шатлан дэвшүүлэх тогтолцоо бүрдүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр гарган хэрэгжүүлэх;
 - 1.3. Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албаны дотоод аудит, чанарын удирдлагын тогтолцоонд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээ авах;
 - 1.4. Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын 2017 онд хийсэн аудитын хүрээнд гарсан зөвлөмж, үл нийцлийг запруулах ажлыг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх ажилд хариуцлагагүй хандсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;
 - 1.5. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан хэрэгжилт удаашралтай байгаа аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх, хариуцлагагүй хандсан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;

| |
|-------------------------------------|
| Бүртгэлийн дугаар ... 29 |
| МОНГОЛ УЛСЫН |
| ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМ |
| ХУУЛЬБАР ҮНЭН |
| Хуульбар олгосон хувьтны гарын үсэг |
| 2021 оны 02 сарын 18-ний өдөр |

69 000355

- 1.6. Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ олгож буй байгууллагуудын аюулгүй ажиллагааны хангарт, дотоод хяналт шалгалтын тогтолцоо, иргэний нисэхийн хууль тогтоомжийн нийцэл, тохирлын байдалд эрсдлийн үнэлгээ хийж, нөхцөл байдлыг тодорхойлох, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох тайланг Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлд танилцуулах;
- 1.7. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчдэд ээлжит бус үзлэг шалгалтыг зохион байгуулах, нисэх багийн сургалт, дадлага, агаарын хөлгийн техникийн бэлэн байдал, нислэгийн аюулгүй ажиллагааны хангарт, чанаарын удирдлагын тогтолцоонд нөхцөл байдлыг тодорхойлох, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох тайланг Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлд танилцуулах;
- 1.8. Автоматжуулалтын Aigcon 2100 системийн доголдлыг 2021 оны 02 дугаар сард багтаан бүрэн арилгах, ашиглалтын байнгын бэлэн байдлыг хангах, уг системийн доголдолтой холбоотой Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан 4 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;
- 1.9. Агаарын навигацийн тоног төхөөрөмж, программ хангамж, технологи ажиллагааны найдвартай, хэвийн үйл ажиллагааг бүрэн хангахад чиглэсэн үзлэг шалгалтыг тусгайлан зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, холбогдох тайланг Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлд танилцуулах;
- 1.10. Агаарын навигаци, нисэх буудлын үйл ажиллагаанд хүний нөөцийн аудит хийх, ажлын байрны шаардлагыг нягтлан үзэх, мэргэжил, туршлагыг харгалзан сонгон шалгаруулах, шатлан дэвшүүлэх тогтолцоо бүрдүүлэх.

2. Сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр:

- 2.1. Нисгэгч, агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтан, нислэгийн хөдөлгөөний удирдагч, нислэгийн мэдээллийн ажилтны мэргэжлийн үнэмлэх олгох шалгуурыг сайжруулах, шалгалтыг гадаадын эрх бүхий мэргэшсэн хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг 2021 оны 6 дугаар сард багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэх;
- 2.2. Тусгайлан эрх олгох нислэгийн дадлагажуурын сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх ажилд анхаарч, нисэх багийн сургалтын хөтөлбөрийг нарийвчлан гаргаж 2021 оны 5 дугаар сард багтаан хэрэгжүүлэх;
- 2.3. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч нарын тусгай сургалт (RVSM, RNP, ETOPS болон бусад)-ын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, шаардлагатай сургалтад 2021 оны 10 дугаар сард багтаан хамруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- 2.4. Нисгэгч, нисэх багийн чадвар, онцгой нөхцөлийн дадлага сургалтын тусгай хөтөлбөрийг боловсруулах, нислэгийн дадлагажуурын эрх бүхий сургалтын байгууллагад агаарын тээвэрлэгчдийн бүх нисгэгчдийг хамруулах судалгааг даруй гаргаж, сургалтыг 2021-2022 онд багтаан зохион байгуулах төлөвлөгөө гарган хяналт тавьж, хэрэгжүүлэх;

Бүртгэлийн дугаар 29
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛЬБАР ҮНЭН
Хуульбар олгосон ажилтны гарын үсэг
.....
2021 оны 02 сарын 18-ний өдөр
.....

2.5. Мэргэжлийн үнэмлэх эзэмшихэд тавигдах шаардлага зөрчигдсөн, мэргэжлийн алдаа дутагдал, зөрчил гаргасан ажилтнуудыг шалгалтад дахин хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах.

3. Иргэний нисэхийн салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах, цахим үйлчилгээ нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:

- 3.1. Иргэний нисэхийн салбарын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахим болгох;
- 3.2. Иргэний нисэхийн дүрмийн дагуу аюулгүй ажиллагааны чиглэлээр гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим болгох;
- 3.3. Мэргэжлийн үнэмлэх эзэмшихэд тавигдах шаардлагыг нягталж, цахим үнэмлэх олгох бэлтгэл ажлыг бүрэн хангаж, хэрэгжүүлэх.
- 3.4. Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын нөөц төв байгуулах судалгаа, тооцоо хийж, бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх чиглэлээр ажиллах;
- 3.5. Даланзадгад, Олгий, Ховд, Чойбалсан хотуудын болон орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр менежментийг хэрэгжүүлэх талаар болон орон нутгийн захиргаанд үе шаттай шилжүүлэх асуудлыг судлан Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлд танилцуулах.

Хоёр. Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг барьж байгуулахад хувийн хэвшил, орон нутгийн оролцоог хангахад чиглэсэн дэд хөтөлбөрийг боловсруулан, 2021 онд багтаан хэрэгжүүлэх.

Гурав. Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилгыг 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор дуусган хүлээн авч, 2021 оны 10 дугаар сарын 01-ний дотор үйл ажиллагааг эхлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Иргэний нисэхийн хангалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" 03 дугаар албан даалгавар, "Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай" 04 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг 2021 оны 5 дугаар сард багтаан бүрэн хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Агаарын тээврийн хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Мөнхтуяа/-т даалгасугай.

Тав. Тушаалын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, сар, улирал тутам тайлагнаж ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Мөнхтуяа/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

